



ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар А/136

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.17, 11.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- 1."Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох журам"-ыг хавсралтаар баталсугай.
- 2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч этгээдэд даалгасугай.
- 3.Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газар (Б.Артур), хяналт тавьж ажиллахыг Төмөр замын тээврийн бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт)-т тус тус үүрэг болгосугай.
- 4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын 2026 оны А/74 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Б.ДЭЛГЭРСАЙХАН